



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

05.25 - 05.29



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин өсөлттэй хаагдлаа. Технологийн компаниудыг илүүтээгээр агуулдаг Nasdaq индекс 2-р сараас хойших хамгийн өндөр ханшдаа ойртсон ч долоо хоногийн сүүлээр дахин унасан байна. Өргөн хэрэглээний бараа үйлчилгээний салбар өсөлттэй байсан бол дотоодын газрын тосны нөөц өссөнтэй холбоотой эрчим хүчний салбар уналттай байсан байна.

Энэ долоо хоногийн эдийн засгийн голлох үзүүлэлтүүд хүлээлтээс эерэг гарсан байна. 4-р сарын удаан эдэлгээт барааны (үүнд тээврийн хэрэгслийн секторыг оруулдаггүй) захиалгын хэмжээ 7.4% буурсан нь таамаглалаас 2 дахин бага байсан юм. Тус долоо хоногт шинээр 2.12 сая Америкчууд ажилгүйдлийн тэтгэмжид бүртгүүлэх хүсэлт гаргасан нь таамаглалаас бага зэрэг өндөр байсан ч урт хугацаандаа тус үзүүлэлт нь буурах төлөвтэй байна. Шинээр баригдаж буй байрны тоо борлуулалтын тоо 4-р сард огцом өссөн боловч, хуучин байрны зарагдах тоо 22%-аар буурсан нь таамаглалаас муу байсан байна.

АНУ болон БНХАУ-ын зөрчилдөөн хурцадмал байдалтай байгаа ч эдийн засгууд хэсэгчлэн нээгдэж эхэлсэн сайн мэдээ нь урт хугацаат бондын өгөөжийг өөрчлөлт багатай, бага зэрэг уналттай хаагдахад нөлөөлжээ.

Европ: Коронавирусийн цар тахлын хоёрдогч давлагаа дэгдэх магадлал мөн АНУ болон БНХАУ-ын хооронд зөрчилдөөн үүсээд байгаа ч эдийн засгууд хэсэгчлэн нээгдэж байгаа болон Европын Холбооноос хэрэгжүүлэхээр зэхэж буй нэмэлт эдийн засгийг дэмжих хөтөлбөрүүдтэй холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. STOXX Europe 600 индекс 3.0%-аар, DAX индекс 5.01%-аар, CAC 40 индекс 6.02%-аар, FTSE MIB индекс 4.90%-аар, FTSE 100 индекс 1.32%-аар тус тус өссөн байна. Евро бүсийн Испани, Португали, Итали, Грек зэрэг улсуудын бондын өгөөж харьцангуй уналттай байсан байна. Европын Төв Банкны дэд ерөнхийлөгч Француа Вилайро де Галау нэмэлт эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн талаар дурдсан нь Даваа гарагт 1.6% байсан Италийн 10 жилийн хугацаатай бондын өгөөжийг Баасан гарагт 1.44% болж буурахад нөлөөлсөн байна.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Nikkei индекс 1,490 пункт буюу 7.31%-ийн өсөлт үзүүлж 21,877.89 болсон боловч өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 7.5% бага байгаа юм. TOPIX large-сар болон small-сар индексүүд аль аль нь өндөр өсөлттэй байсан ч өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 9% ба 11%-аар тус тус бага байна. Энэ долоо хоногт ам.долларын эсрэг иений ханш харьцангуй тогтвортой байлаа.

БНХАУ: БНХАУ-ын эрх баригчид Хонг Конгын автономн засаглалыг халахаар үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг тус улсын газар нутагт мөрдүүлж эхэлсэнд ерөнхийлөгч Дональд Трампын өгөх хариу зэргээс шалтгаалан БНХАУ-ын хөрөнгийн зах зээл энэ долоо хоногт хөдөлгөөн багатай байлаа. Олон хөрөнгө оруулагчид нөхцөл байдлыг ажигласан байр суурьтай байсан учраас арилжааны хэмжээ бага байсан ба А зэрэглэлийн Shanghai Composite индекс 1.4%, CSI 300 large-сар 1.1% тус тус өсөлттэй хаагдсан байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	15,981.56	-0.70% ▼
Dow Jones	АНУ	25,383.11	3.75% ▲
S&P 500	АНУ	3,044.31	3.01% ▲
Nasdaq	АНУ	9,489.87	1.77% ▲
S&P/TSX	Канад	15,192.83	1.87% ▲
FTSE 100	Их Британи	6,076.60	1.39% ▲
S&P/ASX 200	Австрали	5,755.70	4.71% ▲
Nikkei 225	Япон	21,877.89	7.31% ▲
Hang Seng	Хонг Конг	22,961.47	0.14% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	101.46
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	95.43
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	95.40
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	102.76
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.18
DBM' 2023	USD	7.250%	87.44
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	75.33

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.183	0.01 ▲
Libor 3M	0.344	-0.03 ▼
Libor 6M	0.510	-0.06 ▼
Libor 1YR	0.674	-0.01 ▼
US 2YR Bond	0.158	-0.01 ▼
US 3YR Bond	0.191	-0.02 ▼
US 5YR Bond	0.301	-0.03 ▼
US 10YR Bond	0.656	0.00 ▼

Валютын ханш	2020.05.29	Өөрчлөлт
USD	2,805.97	0.17% ▲
CNY	392.59	0.00% ▼
EUR	3,115.89	2.02% ▲
RUB	39.64	1.88% ▲
KRW	2.27	0.44% ▲
JPY	26.18	0.42% ▲
CAD	2,036.71	2.03% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,730.27	-0.25% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	17.87	3.79% ▲
Зэс	USD/lb.	242.55	1.63% ▲
Нүүрс	USD/MT	55.32	-2.52% ▼
WTI газрын тос	USD/bbl.	35.49	6.74% ▲
Brent газрын тос	USD/bbl.	35.33	0.57% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.85	6.94% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. IV	4.7%
Бодлогын хүү	2020. IV	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. IV	9.87%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	11.32%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. IV	4.57%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. IV	10.36%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 42 компанийн 1,332.5 сая төгрөгийн 12,643,122 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хөсөг трейд” /HSG/ компанийн хувьцаа 14.99%-аар буюу хамгийн ихээр өсөж 2,578.00 төгрөг хүрч хаагдсан бол “Талх чихэр” /ТСК/ компанийн хувьцаа 17.29%-аар буурч 2,578.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

05-р сарын 29-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,415.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 15,981.56 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.70%-аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	1,332.5	
Зах зээлийн үнэлгээ	2,415,764.9	
Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	15,981.56	-0.70% ▼
MSE I индекс	7,721.35	-0.20% ▼
MSE II индекс	7,319.77	-0.41% ▼
Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Адуун чулуун	568,449	600,282,144
Монос хүнс	4,533,964	370,305,698
Лэндмн ББСБ	6,736,305	201,057,678
Говь	256,693	48,418,056
Гутал	800	15,824,000
Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хөсөг трейд	2,578.00	14.99% ▲
Булган гурил тэжээл	694.00	14.92% ▲
Фронттиер лэнд групп	340.00	13.33% ▲
Хар хорум пропертийс	290.00	13.28% ▲
Айтүүлс	78.00	6.44% ▲
Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Талх чихэр	11,000.00	-17.29% ▼
Дархан гурил тэжээл	2,825.00	-14.39% ▼
Техник импорт	8,000.00	-14.39% ▼
Жуулчин дютти фрий	68,650.00	-14.13% ▼
Хэрлэн хивс	37.00	-10.63% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)	
Монсек	1,228,289,818	
Голомт Капитал	728,979,338	
Мирэ Эссет Секьюритис Монгол	290,511,111	
БиДиСек	92,124,010	
Гаүли	80,949,990	
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	542.00	576,786
Таван толгой	5,580.00	293,872
МИК Холдинг	11,000.00	227,803
Инвескор ББСБ	2,500.00	179,320
Говь	190.00	148,221

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас Монгол улсыг 2019 оны 10-р сарын 18-ны өдөр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулж 6 үүрэг даалгаврыг өгсөн.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дээрх үүргийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах талаар холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн анхны явцын тайлан, тодруулгыг ФАТФ-ын Олон улсын хяналтын бүлэгт 2020 оны 01-р сард хүргүүлсэн ба Санхүүгийн зохицуулах хороо ФАТФ-аас өгсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлж, саарал жагсаалтаас гарах боломжийг бүрдүүллээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Дараах хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулагдана.

Covid-19-ийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 05-р сарын 29-ний байдлаар дараах хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийхээр шийдвэрлэсэн байна Үүнд:

- “Монгол Керамик” ХК 2020 оны 07-р сарын 05-ны өдрийн 09:00 цагт

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Дархан гурил тэжээл” /MSE: DAR/ ХК-ийн хувьцааны ханш 2 сарын дотор 50%-аар унаад байна.

“Дархан гурил тэжээл” /MSE: DAR/ ХК-ийн хувьцааны ханш даваа гарагт 14.39%-аар буурч 2,825.00 төгрөг дээр хаагдсан бөгөөд ингэснээр ханш нь сүүлийн 2 сарын хугацаанд 50%-ийн уналтыг үзүүлээд байна.

Өмнө мэдээлж байсанчлан 2019 оны эхээр тус компани зах зээл дээр нэмж хувьцаа гаргах болсноо мэдэгдсэн. Үүнтэй холбоотойгоор ханш нь богино хугацаанд 1,000 төгрөгөөс 5,000 төгрөг хүртэл өсөж байсан.

Гэвч нэмж хувьцаа гаргах үйл ажиллагаа зогсонги байдалд орж, энэ оны 04-р сард хуралдсан ХЭХ-аар тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан нь эргээд ханш буурахад гол нөлөөг үзүүллээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Адуунчулуун” /MSE: ADL/ ХК-ийн 18% багцын арилжаагаар арилжаалагдсан байна.

Даваа гарагт МХБ-ийн хувьцааны II ангилалд бүртгэлтэй “Адуунчулуун” /MSE: ADL/ ХК-ийн хувьцаа багцаар арилжигдлаа.

Тодруулбал, тус компанийн нийт хувьцааны 18%-тай тэнцэх 568,449 ширхэг хувьцаа нэг бүр нь 1,056 төгрөгийн ханш дээр зарагдсан ба хэлцлийн нийт үнийн дүн 600.3 сая төгрөг болсон байна.

“Адуунчулуун” /MSE: ADL/ ХК-ийн 87.19%-ийг 3 том хөрөнгө оруулагч эзэмшдэг ба эдгээр хувьцаа эзэмшигч энэхүү арилжааг хийсэн байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Монинжбар” /MSE: MIB/ ХК хэлбэрээ өөрчлөхөөргүй боллоо.

“Монинжбар” /MSE: MIB/ ХК-ийн хувьцаа эзэмшигчид хуралдаж, өнгөрсөн оны үйл ажиллагааны тайлан болон бусад асуудлуудыг хэлэлцлээ.

Энэ удаагийн хурлаар компани хэлбэрээ өөрчилж, ХХК болох тухай асуудлыг хэлэлцэх байсан боловч хувьцаа эзэмшигчид дэмжээгүй тул ямар нэг шийдвэр гаргаагүй байна.

Харин 2019 оны компанийн үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчид баталж, санхүүгийн үр дүнг хангалтгүй гэж дүгнэв.

Эх сурвалж: MarketInfo.mn

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газартай төсвийн дэмжлэгийн тухай санхүүжилтийн хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

Хэлэлцээрийн хүрээнд Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт 50.8 сая еврогийн буцалтгүй тусламжийг 2020-2024 оны хооронд олгоно. Үүнээс 43 сая еврог төсвийн дэмжлэг хэлбэрээр, 7.8 сая еврог нь бодлогын арга хэмжээг дэмжих техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэхэд зарцуулах юм байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Фитч агентлагаас 2020 оны 05-р сарын 29-ний өдөр гаргасан хэвлэлийн мэдээнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В", төлөвийг "Тогтвортой" хэвээр үнэлсэн талаар дурджээ. Коронавирусийн шокийн нөлөөллөөр төсвийн санхүүжилт тасалдаж, гадаад нөхцөл муудсан нь Зээлжих зэрэглэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж байна. Гэсэн хэдий ч үүсээд буй шокоос хамааралтай нөхцөл байдал түр хугацаанд үргэлжлэх төдийгүй 2021 оноос эдийн засаг огцом сэргэж засгийн газрын өр болон ДНБ-ний харьцаа буурах тул Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр хадгалжээ. Фитч агентлаг Монгол улсын эдийн засгийг 2020 онд 2%-аар буурч 2021 онд 7.1%-аар өснө гэж таамаглаж байна.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

БНХАУ-ын эдийн засаг сэргэж эхэллээ гэсэн эерэг дохио гарч байгаагаас шалтгаалаад төмрийн хүдрийн үнэ өсөж байна.

Далянийн Таваарын биржид үнэ нь 0.6%-аар нэмэгдэж, тонн тутамд 710 юань болсон бол Сингапурын биржид 0.8%-аар өсөж, 92.5 ам.доллар хүрээд байгаа юм. Эрэлт талаас БНХАУ-д өөдрөг дүр зурагтай байгаа бол харин нийлүүлэлт талаас Бразилд үүссэн нөхцөл байдал болгоомжлол бий болгож байна. Төмрийн хүдрийн олборлолтоор тэргүүлэгчдийн тоонд ордог Бразилд шинэ төрлийн корона вирусийн тархалт газар авч байгаа, мөн цаг агаарын байдлаас шалтгаалаад нийлүүлэлтэд саатал үүсэх эрсдэлтэй байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.